



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/514

Ховд

Санхүүгийн хяналт, аудитын албаны
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, 69.5, Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 275 дугаар тогтоол, 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралт “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.1,8.3, Санхүүгийн хяналт, аудитын албаны дунд хугацааны Стратеги төлөвлөгөөний 2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны бүтэц орон тоог хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Албаны бүтэц, орон тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан албан хаагчдын цалингийн сан, бусад зардлыг орон нутгийн төсөвт тусган батлуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.


3. Албаны дүрэм, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг зорилго, зорилт, хэтийн төлөвлөгөө, ажлын чиг үүрэгтэй нягт уялдуулан боловсруулж, үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга /Г.Өөдэй/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А/ 514 дүгээр захирамжийн хавсралт



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/Д	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын ангилал, зэрэглэл
1	Дарга	1	T3-10
2	Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч	1	T3-7
3	Ахлах дотоод аудитор /Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагчийн эрхтэй/	1	T3-7
4	Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч	3	T3-6
5	Дотоод аудитор	3	T3-6
6	Дотоод ажилтан /санхүү, актны төлбөр хариуцсан мэргэжилтэн/	1	TY-8
7	Жолооч	1	TY-3

-oOo-